

Сургуулиудыг хаах тухай мэдээлэл

Эрхэм хүндэт ба хайрт аав ээж нар аа,

Одоо их төвөгтэй нөхцөл байдал гарсан ба та нар нэлээд олон өдөр тумын асуудлуудыг шийдвэрлэх ба бэрхшээлүүдийг давах ёстой гэдгийг бид ойлгож байна. Хамгийн их том хүндрэлтэй асуудлуудын нэг нь алслагдсан сургууль байж болох нь магадгүй. Сургуулийг бодит амьдралаас холдуулж сургуульд явахгүй байхдаа суульгуулийн хичээл хийх хэрэггүй гэж Та бодож магадгүй. Гэвч анхаараарай, тэгэж бодож болохгүй! Удаан хугацаагаар сургуульдаа явахгүй байхад Таны хүүхэд нь чех хэлнээс бүр илүү холдож байгаад дараа нь хоцрогдсон хичээлээ сурахад их хэцүү байдаг. Юу вэ гэхэд, дараагийн нэг хэдэн долоо хоногт суургуульд явж болохгүй нь магадлалтай байна.

Тийм учраас Таны хүүхэд сургуульд яваагүй ч гэсэн хичээлээ давтаж байвал их чухал ач холбогдолтой юм. Хэрвээ Та хүүхдийн явж байгаа сургуулийн төлөөлөгчтэй холбоо бариагүй байвал, ангийн багштай нь заавал холбогдоно уу (буюу сургуулийн захиргаатай), тэгээд алслагдсан сургалт нь ямар аргаар явж байгаа тухай мэдээлэл олж авна уу.

(Энд тодорхой холбоо барих тухай зааж өгнө үү:)

- Хэрвээ Та чех хэл сайн мэдэхгүй учраас чех хэлээр сайн ярьж чадахгүй байвал, Прага хотод байгаа ТББ-ын дагалдаж явдаг орчуулагчдын үйлчилгээ ашиглаж болно, жишээлвэл, META байгууллага, нийтийн эрх ашигтай холбоо, (www.meta-ops.cz, и-мэйл: poradenstvi@meta-ops.cz, гар утас: +420 773 304 464,), Интеграцийн төв Прага, (<https://icpraha.com/tlumoceni-online/>),
- Прага хотоос гадна Интеграцийн төвийн салбарууд нь Чех улсын аймаг болгонд байдаг (<http://www.integracnicentra.cz>), тэд нарт хандаж Та нар сургуультай холбоо барихад тэндэхи орчуулагч буюу нийгмийн ажилтнаас тусламж авч болно.
- Бүх орчуулагч нарын үйлчилгээнүүд нь үнэ төлбөргүй.
- Таны сургууль нь Чех Улс дахь Үндэсний сурган хүмүүжүүлэх хүрээлэнгийн гаргасан санал бодлыг дэмжиж, Таны хүүхдийг боловсролоор хангах тухай үндсэн мэдээллийг орчуулж өгөхийг шаардаж болно, ингэж суургуулиас гарсан заавруудыг ойлгох боломжтой болно. Хэрвээ сургуулиас гаргасан заавруудыг ойлгохгүй байвал (<https://cizinci.npicr.cz/tlumoceni-a-preklady/>), энэ үндсэн заавруудыг орчуулж өгөхийг шаардаж болно, битгий айгаарай, асуугаарай. Онцгой тохиолдолд интернэт ашиглаж google орчуулагчийг хэрэглэнэ үү (<https://translate.google.com/>).

Хэрвээ Та буюу Таны хүүхэд нь **өгсөн даалгавруудыг ойлгохгүй проблем** гарч ирвэл буюу Таны хүүхэд сургуулийн даалгавруудыг хийж чадахгүй байвал, ангийн багштай нь

Dostupné z portálu www.inklusivniskola.cz, vytvořeného společností META, o.p.s. za finanční podpory Ministerstva školství, mládeže a tělovýchovy ČR. Provoz portálu je spolufinancován z prostředků Evropského fondu pro integraci státních příslušníků třetích zemí.

Dostupné z portálu <https://cizinci.npicr.cz/>



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



холбоо барьж, даалгавруудыг ойлгохгүй байна буюу хийж чадахгүй байна гэж **ангийн багшид нь мэдээлэл өгөх хэрэгтэй** (ийм тохиолдол олон гэр бүлд гарч байна).

Сургууль яг хэдүйд дахин нээгдэж болохыг одоогийн үед харамсалтай нь хэлж чадахгүй байна. Боловсролын, залуучуудын ба биеийн тамирын яамны мэдээллийн дагуу сургуулиуд нь хамгийн туруунд 5-р сарын дундуур нээгдэх гэж бодогдож байна.

Цаашдах мэдээллийг Таны сургуулийн вэб-хуудсаас үзнэ үү:
буюу, жишээлвэл, META байгууллагын вэб хуудсыг үзнэ үү - www.meta-ops.cz,
буюу англи хэлээр нийтлэгдсэн вэб-хуудсууд: <https://www.mvcr.cz/mvcren/> байна,
<https://metropolevsech.eu/en/news/> (энэ хуудсууд олон хэлээр нийтлэгдсэн байгаад Чех Улсын байдлын тухай үндсэн мэдээлэл агуулдаг)
буюу фэйсбуук үзнэ үү: <https://www.facebook.com/metapromigranty>.

Бид үүнийг хамтын хүчээр зохицуулж чадна!

*Dostupné z portálu www.inkluzivniskola.cz, vytvořeného společností META, o.p.s. za finanční podpory Ministerstva školství, mládeže a tělovýchovy ČR. Provoz portálu je spolufinancován z prostředků Evropského fondu pro integraci státních příslušníků třetích zemí.
Dostupné z portálu <https://cizinci.npocr.cz/>*



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

